



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Дэн буудал. Ерөнхий шаардлага

MNS 5738: 2007

Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот

2025 он

Өмнөх үг

Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ) нь Олон улсын стандартчиллын байгууллагын гишүүн бөгөөд үйл ажиллагааныхаа хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран үндэсний стандартчиллын бодлогыг хэрэгжүүлэх ажил эрхэлдэг.

Үндэсний стандартын төслийг салбарын стандартчиллын техникийн хороо (ТХ), дэд хороо (ДХ)-ны хурлаар хэлэлцэж 75-аас доошгүй хувиар дэмжсэн тохиолдолд Стандартчиллын үндэсний зөвлөл (СҮЗ)-ийн хурлаар хэлэлцэн батална.

Энэхүү стандартыг

.....
боловсруулсан болно.

Уг стандартыг Аялал жуулчлалын стандартчиллын дэд хорооны хурлаар хэлэлцэж дэмжсэн болно.

Стандартчилал, хэмжил зүйн газар (СХЗГ)

Энхтайваны өргөн чөлөө 46А

Улаанбаатар 13343, Ш/Х - 48

Утас: 266754, 263860 Факс (976-11) 458032

E-mail: standardinform@masm.gov.mn, www.estandard.mn

© СХЗГ 2013

“Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн дагуу энэхүү стандартыг бүрэн эсвэл хэсэгчлэн хэвлэх, олшруулах эрх нь гагцхүү СХЗГ (Стандартчиллын төв байгууллага) - д байна.

Ангилалтын код

Дэн буудал. Ерөнхий шаардлага	
Hostel. General requirements	

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2024 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ... дугаар тогтоолоор батлав.

Энэ стандарт нь улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Зорилго

Энэхүү стандарт нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, дэн буудлын ажил үйлчилгээний хэм хэмжээг тогтооход оршино.

2. Хамрах хүрээ

Монгол улсын нутаг дэвсгэрт дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх бүх иргэн, аж ахуйн нэгж энэхүү стандартын шаардлагыг биелүүлж ажиллана.

3. Норматив ишлэл

MNS 5409:2004 “Чөлөөт цаг, Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томъёо”
MNS4946:2019 “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Хоолны газрын ангилал, зэрэглэл.Ерөнхий шаардлага”
MNS 4597:2003 “Замын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага”
MNS 5342:2007 “Автомашин зогсоол, ангилал, ерөнхий шаардлага”
MNS 4244:1994 “Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага”
MNS 0900:2005 “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ”
MNS 5344:2011 “Ахуйн хог хаягдал тээвэрлэлт. Ангилал. Ерөнхий шаардлага”
MNS 5283:2014 “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага”
БНБД 31-03-03 “Олон нийт иргэний барилга”
БНБД 3.05.06.90 “Цахилгаан техникийн ажил”
БНБД 21.01.02 “Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал”
БНБД 40-01-06 “Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж”
БНБД 41-01-02 “Халаалт, салхивч ба агааржуулалт”
БНБД 2.01-85 Галын аюулгүйн дүрэм

4. Нэр томъёо тодорхойлолт

4.1 Дэн буудал нь гадаад, дотоодын иргэд, жуулчдыг байрлуулахад зориулагдсан, төв суурин газарт байрласан, хоноглуулах үйлчилгээ үзүүлэх, нэмэлтээр өглөөний цай, **хоолоор үйлчлэх боломжтой** бөжөн-хязгаарлагдмал үйлчилгээтэй аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын **буудлын** төрөл

5. Ерөнхий шаардлага

1. Дэн буудлын гадаад, дотоод орчин нь зочны амь нас аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2. Дэн буудал нь өөрийн байранд хоолны газаргүй бол эрх бүхий зөвшөөрөлтэй хоолны газартай гэрээ байгуулсан байна.
3. Барилга байгууламжийг **улсын комисст хүлээлгэн өгсөн** эсвэл барилгын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан байна.
4. Галын дүгнэлт хийлгэсэн байна.
5. Байгууллагын эрх бүхий албан тушаалтны баталсан бүтэц, орон тоо, ажил үүргийн хуваарь, дотоод журамтай бусад дүрэм журмыг мөрдөж ажиллана.
6. **Ахуйн зориулалт бүхий цэвэрлэгээ ариутгал өнгөлгөөний бодис ашигладаг байх**
7. Цэвэрлэгээний график гаргаж мөрдөж ажиллана.
8. Утаат тамхи хэрэглэхгүй зочны өрөөтэй байна.
9. Утаат тамхи татах тусгай цэгийг байгуулж, тогтмол цэвэрлэгээ хийж, хяналт тавина.
10. Байнгын халуун, хүйтэн усан хангамжтай байна.
11. Дэн буудлын өрөө тасалгаа нь 18⁰ С-ээс доошгүй дулаантай байна.
12. Дэн буудал нь 3-аас дээш тооны өрөөтэй байна.
13. Зориулалтын угаалгын хэсэгтэй байна. Гадагшаа зөөвөрлөдөг бол угаалгын байгууллагатай хийсэн гэрээтэй байна.
14. Орны тоогоор 2 ээлжийн цагаан хэрэглэлтэй байна.
15. Цагаан хэрэглэлийн зориулалтын шүүгээтэй байна.
16. Дотоод бүртгэлийн программ, дотоодын бүртгэлийн системд холбогдсон байна.
17. Төвийн дулаангүй тохиолдолд байгаль орчинд ээлтэй, цахилгаан болон хийн түлшээр халаалтыг шийдвэрлэсэн байна.

6. Гадна орчны шаардлага

1. Дэн буудал нь оноосон нэртэй байх ба “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий шаардлага” MNS5283:2014 стандартын шаардлагад нийцсэн хаяг, гэрлэн чимэглэлтэй байна.
2. Дэн буудлын барилга байгууламж нь өнгө үзэмтэй орчны тохижилтод нийцсэн загвар хийцтэй байна.
3. Дэн буудлын барилгын орчинд ногоон байгууламж бий болгосон байна.
4. Гадна талбай, орчинд хогийн савтай байна.
5. **Гадна талбайн орох хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зориулалтын гарц, шатны хэсгээр налуу гадаргуу бүхий дамнуур хэсэгтэй байна.**

7. Аюулгүй байдлын шаардлага

1. Зочдын аюулгүй байх нөхцөлийг **бүрэн** хангасан байна.
2. Тухайн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангаж онцгой байдлын газраас дүгнэлт гаргуулсан байна.
3. Хийн түлшний ашиглалт, ажиллагааны монтаж угсралтад гэрээт байгууллагын дүгнэлт гаргуулсан байна.
4. Зочны өрөөнөөс бусад хэсгүүдийг камержуулсан байна.
5. 24 цагийн ажиллагаатай камерын хяналтын дэлгэц нь зочин хүлээн авах хэсэгт эсвэл харуул хамгаалалтын ажилтан дээр байрлана. Зориулалтын гар утасны **апп ашигладаг бол давуу тал болно.**
6. Барилгын шат, хонгил, галын гарцаар аваарын гэрэл байрлуулж, объектын гадна орчныг бүрэн гэрэлтүүлэгтэй байлгана.
7. Зочны өрөөний гадна хаалга галын аюулгүй байдал болон дуу чимээ тусгаарлах шаардлага хангасан байна.

- ~~8. Хамгаалалтын ажилтан эсвэл гэрээт хамгаалалтын албатай байх ба гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж бүхий тусгай буланг зочин хүлээн авах хэсэгт байршуулна.~~
9. Дөрөв ба түүнээс дээш давхартай барилга нэгээс цөөнгүй цахилгаан шаттай байна.
10. 30 түүнээс олон зочид хүлээн авах хүчин чадалтай дэн буудлын барилга нь галын дуут дохионы тоноглолтой байна.
11. Зочны өрөөний хаалган дээр буюу түүний орчимд галын аюулаас урьдчилан сэргийлэх, аюулын үед дагаж мөрдөх зааварчилгаа, галын гарцын бүдүүвчийг байрлуулсан байна.

8. Нийтийн үйлчилгээний талбайн шаардлага

1. Үүдний хэсэгтэй байна.
2. Нийтийн ариун цэврийн өрөөтэй байна.
3. Нийтийн ариун цэврийн өрөө нь хүйс ялгасан тэмдэгтэй, түгжээтэй байна.
4. Нийтийн арга хэмжээний үеэр хүрэлцэхүйц тооны гадуур хувцасны өлгүүрийн өрөөтэй байна.
5. 10 хүн тутамд 1 суултуур, 1 шээлтүүр, 1 угаалтууртай байна.
6. Ариун цэврийн өрөө нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэргэнцрийн зам, ариун цэврийн тоноглолтой байна.
7. Буудлын бүх хэсгүүд ердийн болон автомат агааржуулалтын системтэй байна.
8. Нийтийн талбайд зориулалтын ус цэвэршүүлэгч байрлуулна.
9. Богино долгионы зуух, хөргөгчтэй байна.
10. Зочдод зориулсан хүлээлгийн сандал ширээ байрлуулсан байна.
11. Зочид хялбар ойлгох мэдээлэл, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан байна.

9. Зочин хүлээн авах хэсэгт тавигдах шаардлага

1. Зочин хүлээн авах ажлын байртай байна.
2. Мэргэжлийн зочин хүлээн авах ажилтантай байна.
3. Зочин 24 цагийн турш хүлээн авч байрлуулах, үдэх үйлчилгээ үзүүлнэ.
4. Үнийн тарифыг Монгол Англи хэл дээр ил харагдах газар байршуулсан байна.
5. Үндсэн болон нэмэлт үйлчилгээнүүдийн үнэ төлбөр, захиалга, цуцалтын талаар ойлгомжтой тайлбарласан байна.
6. Үнэн зөв, бодит мэдээлэл бүхий цахим хуудастай байна.
7. Зочны хувийн эд зүйлс хадгалах сейфтэй байх бөгөөд камерын хяналтад байлгана.
8. Анхны тусламж үзүүлэх эмийн сантай байна.
9. Нэгээс доошгүй зээлийн картаар үйлчилнэ.
10. Кабелийн суваг бүхий өнгөт зурагт байрлуулна.
11. Суурин утастай байна.
12. Шаардлагатай үед холбогдох утасны жагсаалт байрлуулна.
13. Утасгүй интернэтийн үйлчилгээгээр хангана.

10. Зочны өрөөнд тавигдах шаардлага

1. Зочны өрөөний дугаар нэр тодорхой харагдахуйц байна.
2. Өрөөний хаалга нь үндсэн болон нэмэлт цоожтой байна.
3. Нэг хүний өөрөө 8м², хоёр хүний өрөө 12 м²-аас багагүй талбайтай байна. Үүнд ариун цэврийн өрөө, хонгилын зай хамаарахгүй.

4. Зочны өрөөний таазны **өндөр 2.5** метрээс багагүй, давхрын хонгилын өргөн 1.5 метрээс багагүй, шатны өргөн 1.3 метрээс багагүй байна. Нэг хүний ор 200см х 90см-ээс багагүй хэмжээтэй байна.
5. Ор нь 12 см-ээс дээш зузаантай матрастай байна.
6. Зориулалтын гудаастай байна. **Эко материалаар хийгдсэн бол давуу тал болно.**
7. Зочид буудлын зориулалттай цагаан хэрэглэлтэй байна.
8. Орны цагаан хэрэглэлийг зочны хүсэлтээр солих ба эко санамж байрлуулна.
9. Зочны өрөөнд орны тоогоор 3-аас доошгүй хувцасны өлгүүр, мөр өлгүүр байрлуулна.
10. Зочны орны дэргэд зориулалтын шүүгээ байрлуулна.
11. Салхивч бүхий цонхтой байна
12. Тагтай хогийн сав байрлуулна.
13. Гэрэл **нэвтрүүлдэггүй** зориулалтын хөшигтэй байна.
14. Дэн буудлын нэмэлт үйлчилгээ болон үзвэр үйлчилгээ, аяллын хөтөлбөр зэргийг агуулсан мэдээллээр хангадаг байна.
15. Ус буцалгагч, цайны иж бүрдэлтэй байна
16. Зочны хүсэлтээр нэг удаагийн хэрэглэлээр хангах боломжтой байна.
17. Дэн буудлын орчинд тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан байна.
18. Алсын удирдлага бүхий өнгөт зурагт байрлуулна.
19. Зочны өрөөнд толь байрлуулна.
20. Өрөө бүрд орны тоогоор сандал байрлуулна.
21. Зочны өрөө нь нэгдсэн болон хэсгийн гэрэлтүүлэгтэй байна.
22. Орны дэргэд цахилгааны залгуур, гэрлийн удирдлагуудыг байрлуулсан байна.
23. Өрөөнд гар чийдэн тавьсан байна.

11. Зочны өрөөний ариун цэврийн өрөөнд тавигдах шаардлага

1. Ариун цэврийн **өрөөний нийт** багагүй байна.
2. Ариун цэврийн өрөө нь халуун, хүйтэн усаар хангагдсан байна.
3. Ариун цэврийн өрөө нь усны онгоц эсвэл шүршүүр, суултуур, угаалтууртай байна.
4. Усны онгоц, шүршүүр нь тусгаарлагч хаалттай байна
5. Угаалтуурын дээр толь байрлуулна. Толинд тусгалтай гэрэлтүүлэгтэй байна
6. Хөвөн даавуун материалаар хийгдсэн 40см х 50см-ээс багагүй хэмжээтэй гарын алчуур, 60см х 120см-ээс багагүй хэмжээтэй биеийн алчуур байна.
7. Нэг хүнд 1 банны алчуур 1 гарын алчуур ноогдохоор байна.
8. Нэг удаагийн хэрэглээний гарын саван, шүдний сойз ОО тавьсан байна.
9. Ариун цэврийн цаас болон тогтоогчтой байна.
10. Агааржуулалтын системтэй байна.
11. Банны өрөөнд угааж цэвэрлэхэд хялбар, халтирдаггүй резинэн шалавчтай байна.
12. Зочны тоогоор усны шаахай байрлуулна.
13. Хувцас өлгөх өлгүүртэй байна.
14. Алчуур хатаагч байрлуулна.
15. Ванн, шүршүүрийн дэргэд аюулгүйн бариул тогтоосон байна
16. Угаалтуурын толины хажууд ус нэвтрэхээс хамгаалсан цахилгааны залгуур байрлуулна.
17. Тагтай хогийн савтай байна.

12. Угаалгын хэсгийн шаардлага

1. Дэн буудал нь дэргэдээ зориулалтын угаалгын хэсэгтэй байна.

2. Хэрэв гадуур зөөвөрлөн угаалгадаг бол мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулж төлбөр төлсөн болон ажил гүйцэтгүүлсэн баримттай байна.
3. Угаалгын хэсэг нь зориулалтын, бүрэн ажиллагаатай автомат угаалгын машин, автомат хатаагчтай байна.
4. Зориулалтын индүүдлэгийн хэсэгтэй байна
5. Угаалгын хэсэг нь агааржуулалтын системтэй байна.
6. Бохир цэврийн технологийн урсгалыг зөв зохион байгуулсан байна.
7. Цэвэр эдлэлийг хадгалах зориулалтын тавиур шүүгээтэй байна. Бүрэн тэмдэгжүүлсэн байна.
8. Бохир болон цэвэр эдлэлийг зөөвөрлөх битүүмжлэлтэй зориулалтын савтай байна.
9. Лабораторийн шинжилгээний бичигтэй зориулалтын угаалгын бодисыг хэрэглэнэ. Эко тэмдэглэгээ шошготойг хэрэглэдэг бол давуу тал болно.
10. Зориулалтын зөөвөрлөлтийн тэргэнцэртэй байна.
11. Техник, технологи, аюулгүй ажиллагааны зааварчилгаа бүхий тэмдэгжүүлэлт санамжуудыг байрлуулсан байна.

13. Хүний Нөөцийн шаардлага

1. Ажилчид зочид буудлын ажил гүйцэтгэлийн журамд заасан ажил үүргийг мэргэжлийн төвшинд хийх чадвартай байна.
2. Тухайн ажлын байр бүрд мэргэжлийн буюу мэргэшсэн ажилтантай байна.
3. Удирдах ажилтан нь зочлох үйлчилгээний чиглэлийн мэргэжилтэй эсвэл мэргэшсэн байна.
4. Дэн буудлын үйлчилгээний ажилчид нь дүрэмт хувцас, энгэрийн тэмдэгтэй байна.
5. Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна.

14. Нийгмийн хариуцлага

1. Үндсэн ажилчид нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагдсан байна.
2. Цагийн болон гэрээт ажилчин ажиллуулдаг журамтай байна.
3. Хог, хаягдлыг ангилж, хадгалалт, тээвэрлэлтийг холбогдох журмын дагуу хийнэ.
4. Ундны ус, ахуйн ус, эрчим хүчний тоолууртай, хэрэглээний бүртгэл хөтөлдөг байна.
5. Буудлыг сүүн (люминесцент) чийдэнгээр бүрэн тоногдсон байна.
6. Саарал ус гаргах, эргүүлэн ашиглах санаачилга гаргасан байна.
7. Усны түвшин тохируулагч бүхий ус хуримтлуулагчтай суултуураар тоногдсон байна.
8. Эко санамжууд байрлуулна.

15. Бусад шаардлага

1. Дэн буудлын орчны талбай, барилга байгууламжийн засвар үйлчилгээ тогтмол хийж цэвэр цэмцгэр байлгана.
2. Тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны үзлэгийг тогтмол хугацаанд хийж баталгаажуулна.
3. Зочид буудал болон түүний орчинд хортон шавжийн устгал, ариутгал, халдваргүйжүүлэлтийг тодорхой хугацаанд хийж баталгаажуулсан байна.

4. Эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын холбогдох стандартуудыг мөрдөж ажиллана.

ТӨГСӨВ.